

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2023/58/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас:99417382 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл.....	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БУЯНТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА А.ЕЛЖАН ТАНАА

2023.02.17 № 100
танай _____ -ныг № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны 11 дүгээр сард Эрүүл мэндийн яамны магадлан итгэмжлэхийн шалгалтад орсон байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>64,346,941.75</u>	<u>111,466,413.68</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	19,663,769.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	19,663,769.00
3121	Төгрөг	-	19,663,769.00
31211	Төрийн сангийн харилцах		19,663,769.00
33	АВЛАГА	42,322,500.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	42,322,500.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	22,024,441.75	91,802,644.68
351	Түүхий эд материал	12,692,104.00	81,251,920.90
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал	12,692,104.00	81,251,920.90
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	9,332,337.75	10,550,723.78
35410	Бичиг хэргийн материал	1,018,788.00	62,000.00
35420	Аж ахуйн материал	2,266,185.00	739,685.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	378,699.31	
35450	Барилгын засварын материал		
35460	Хүнсний материал	5,668,665.44	9,749,038.78
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>422,982,855.60</u>	<u>396,333,067.51</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	422,982,855.60	396,333,067.51
391	Газар		
392	Биет хөрөнгө	417,950,855.60	391,301,067.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	352,772,600.00	352,772,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,539,128.92)	(44,492,063.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	91,317,511.00	61,581,077.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(42,183,682.70)	(28,040,523.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	98,221,649.08	128,908,313.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,120,106.70)	(84,929,984.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,104,847.84	37,849,880.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,622,834.00)	(32,348,232.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	128,000.00	128,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(128,000.00)	(128,000.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	5,032,000.00	5,032,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	550,000.00	550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,032,000.00	5,032,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>487,329,797.35</u>	<u>507,799,481.19</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>21,608,179.00</u>	-

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,608,179.00	-
413	Өглөг	21,608,179.00	-
4136	Бусад өглөг	21,608,179.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	21,608,179.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	465,721,617.75	507,799,481.19
51	Засгийн газрын хувь оролцоо	465,721,617.75	507,799,481.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	263,882,593.00	263,882,593.00
51101	Өмч: - төрийн	263,882,593.00	263,882,593.00
512	Хуримтлагдсан үр дүн	118,804,784.87	161,739,835.31
51210	Өмнөх үеийн үр дүн	118,804,784.87	119,661,971.87
51220	Тайлант үеийн үр дүн		42,077,863.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	83,034,239.88	82,177,052.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	487,329,796.75	507,799,481.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	721,256,536.23	640,488,732.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	230,584,395.23	132,589,942.15
120	Нийтлэг татварын бус орлого	230,584,395.23	132,589,942.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	230,584,395.23	132,589,942.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		47,977,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	230,584,395.23	84,612,442.15
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	490,672,141.00	507,898,790.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	357,200,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	357,200,700.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,030,541.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,030,541.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,535,900.00	28,799,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,535,900.00	28,799,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	63,905,000.00	479,099,790.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	63,905,000.00	479,099,790.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	504,968,534.13	594,627,932.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	504,968,534.13	594,627,932.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,568,534.13	594,627,932.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,500,773.00	330,775,350.00
210101	Үндсэн цалин	185,857,961.00	224,936,146.00
210102	Нэмэгдэл	75,421,612.00	79,900,249.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,292,000.00	5,101,000.00
210104	Урамшуулал	25,929,200.00	20,837,955.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,351,220.00	43,348,300.00

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	28,196,820.00	30,265,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,788,600.00	3,270,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,230,800.00	2,616,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	557,800.00	654,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,577,200.00	6,541,600.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,323,840.00	26,245,699.31
210301	Гэрэл, цахилгаан	1,008,200.00	2,008,200.00
210302	Түлш, халаалт	12,315,640.00	24,237,499.31
2104	Хангамж, бараа материалын зардал	37,244,047.00	65,399,188.00
210401	Бичиг хэрэг	1,440,900.00	7,732,888.00
210402	Тээвэр, шатахуун	31,684,847.00	49,080,390.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,851,800.00	1,875,660.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,266,500.00	2,295,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,414,750.00
2105	Нормативт зардал	58,284,706.44	57,970,221.66
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,488,225.24	42,613,295.00
210502	Хоол, хүнс	5,646,181.20	4,732,226.66
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,150,300.00	10,624,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,526,400.00	6,576,588.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	916,400.00	2,566,188.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	610,000.00	4,010,400.00
2107	Томилолт, зочны зардал	2,482,831.00	754,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,482,831.00	754,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	585,600.00	486,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	354,450.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,800.00	17,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,600.00	44,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	67,400.00	50,320.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	76,800.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,269,116.69	63,072,415.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	3,399,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,769,116.69	59,673,415.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,400,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,400,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	216,288,002.10	45,860,799.46

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,782,936.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		2,478,036.02
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		1,304,900.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,782,936.02)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>216,288,002.10</u>	<u>42,077,863.44</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>448,349,641.00</u>	<u>598,198,790.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	47,977,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	47,977,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	47,977,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		47,977,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	448,349,641.00	550,221,290.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	357,200,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	357,200,700.00	
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	56,030,541.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,030,541.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,535,900.00	28,799,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	13,535,900.00	28,799,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	21,582,500.00	521,422,290.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,582,500.00	521,422,290.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>446,499,641.00</u>	<u>574,885,021.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,499,641.00	574,885,021.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,099,641.00	574,885,021.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,500,773.00	330,775,350.00
210101	Үндсэн цалин	185,857,961.00	224,936,146.00
210102	Нэмэгдэл	75,421,612.00	79,900,249.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,292,000.00	5,101,000.00
210104	Урамшуулал	25,929,200.00	20,837,955.00
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,351,220.00	43,348,300.00
210201	Тэтгэврийн даатгал	28,196,820.00	30,265,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,788,600.00	3,270,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,230,800.00	2,616,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	557,800.00	654,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,577,200.00	6,541,600.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,803,900.00	25,867,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,008,200.00	2,008,200.00
210302	Түлш, халаалт	11,795,700.00	23,858,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,846,117.00	64,313,830.00
210401	Бичиг хэрэг	1,440,900.00	5,249,600.00
210402	Тээвэр, шатахуун	29,286,917.00	50,478,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,851,800.00	1,875,660.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,266,500.00	2,295,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,414,750.00
2105	Нормативт зардал	30,502,800.00	99,364,783.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,251,500.00	79,927,483.00
210502	Хоол, хүнс	7,101,000.00	8,812,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,150,300.00	10,624,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,526,400.00	6,576,588.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	916,400.00	2,566,188.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	610,000.00	4,010,400.00
2107	Томилолт, зочны зардал	2,482,831.00	754,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	2,482,831.00	754,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	585,600.00	486,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	354,450.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,800.00	17,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,600.00	44,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	67,400.00	50,320.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	76,800.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	3,399,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	3,399,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,400,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	29,400,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,850,000.00</u>	<u>23,313,769.00</u>

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,850,000.00	3,650,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,850,000.00	3,650,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,850,000.00	3,650,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,850,000.00	3,650,000.00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,850,000.00)</u>	<u>(3,650,000.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		19,663,769.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	118,804,784.87		465,721,617.75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	118,804,784.87	-	465,721,617.75
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
C07	Тайлант үеийн үр дүн					-
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	118,804,784.87	-	465,721,617.75
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	118,804,784.87	-	465,721,617.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			857,187.00		857,187.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	263,882,593.00	83,034,239.88	119,661,971.87	-	466,578,804.75
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(857,187.00)			(857,187.00)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D08	Тайлант үеийн үр дүн			42,077,863.44		42,077,863.44
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	263,882,593.00	82,177,052.88	161,739,835.31	-	507,799,481.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	695,452,100.00	578,255,021.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	695,452,100.00	578,255,021.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	695,452,100.00	578,255,021.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	381,341,800.00	330,775,350.00
210101	Үндсэн цалин	235,375,400.00	224,936,146.00
210102	Нэмэгдэл	114,298,400.00	79,900,249.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,273,000.00	5,101,000.00
210104	Урамшуулал	25,395,000.00	20,837,955.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,850,100.00	43,348,300.00
210201	Тэтгэврийн даатгал	33,326,500.00	30,265,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,630,900.00	3,270,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,904,700.00	2,616,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	726,100.00	654,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,261,900.00	6,541,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,867,000.00	25,867,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,008,200.00	2,008,200.00
210302	Түлш, халаалт	23,858,800.00	23,858,800.00
210303	Цэвэр, бохир ус		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	76,900,500.00	64,814,018.00
210401	Бичиг хэрэг	5,282,000.00	5,249,600.00
210402	Тээвэр, шатахуун	60,397,900.00	50,378,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,936,700.00	1,875,660.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,283,900.00	2,895,688.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	4,414,750.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	138,090,300.00	99,364,783.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,209,500.00	79,927,483.00
210502	Хоол, хүнс	18,880,800.00	8,812,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,000,000.00	10,624,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,236,400.00	9,626,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,616,000.00	5,616,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	5,620,400.00	4,010,400.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	574,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	574,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,800.00	486,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	354,450.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,800.00	17,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,600.00	44,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,000.00	19,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
210807	Газрын төлбөр	67,400.00	50,320.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,657,200.00	3,399,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,657,200.00	3,399,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	695,452,100.00	597,918,790.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,799,000.00	28,799,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	28,799,000.00	28,799,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	666,653,100.00	569,119,790.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	666,653,100.00	569,119,790.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	25.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	6.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.00	25.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	17.00	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	4.00	6.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй байгууллага.

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд “Үр дүнтэй манлайлал бүхий хамт олныг бүрдүүлэн байгууллагын хөгжлийг хангаж, харьяа нутгийн хүн амын эрүүл мэндэд ээлтэй, чанартай, цогц тусламж үйлчилгээг үзүүлэх замаар орон нутгийн хөгжил, амьдралын чанарыг сайжруулах” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй, нээлттэй байх
- Эрүүл энх, эрх тэгш байх
- Чанартай, хүртээмжтэй, цогц байх
- Ёс зүйтэй, мэдрэмжтэй байх
- Өндөр мэргэшсэн, сайн чадавхтай байх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- ❖ Эрүүл мэндийн тухай хууль
- ❖ Бага дунд боловсролын тухай хууль
- ❖ Төрийн албаны тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Шилэн дансны тухай хууль
- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ❖ Татварын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, Эрүүл мэндийн сайдын харьяа Эрүүл мэндийн ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн сайдын 2010 оны “Эрүүл мэндийн яамны салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах тухай” 138 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдсөн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20.5 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		19,663.8	19,663.8
Авлага	42,322.5		(42,322.5)
Бараа материал	22,024.4	91,802.6	69,778.2
Үндсэн хөрөнгө	422,982.9	396,333.1	(26,649.8)
Нийт хөрөнгө	487,329.8	507,799.5	20,469.7
Өр төлбөр	21,608.2		(21,608.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	465,721.6	507,799.5	42,077.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	487,329.8	507,799.5	20,469.7

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос мөнгөн хөрөнгө 19.7 сая төгрөгөөр, бараа материалын данс 69.8 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо данс 42.1 сая төгрөгөөр тус тус өсөж, авлагын дансны үлдэгдэл 42.3 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 26.6 сая төгрөгөөр, өр төлбөрийн дансны үлдэгдэл 21.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Оны эцэст улсын төсвийн санхүүжилтээс 19.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлын төсвийн хэмнэлт байна.

Оны эхний 42.3 сая төгрөгийн санхүүжилтийн авлагыг бүрэн барагдуулсан.

Оны эхэнд бараа материалын данс 22.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр нийт 167.0 сая төгрөгийн, үнэгүй 52.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч 148.6 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор хугацаа дууссан 65 нэр төрлийн 1.3 сая төгрөгийн эмийг акталж данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 585.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба төсвийн хөрөнгөөр 3.6 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч 31.8 сая төгрөгийн дансны үнэтэй хөрөнгийг үнэгүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бараа материалын шинжтэй үндсэн хөрөнгийн данс бүртгэлд байсан 97 нэр төрлийн 4.0 сая төгрөгийн хөрөнгийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар хуралдааны тогтоолоор акталж данс бүртгэлээс хассан байна.

Эрүүл мэндийн төвийн 2017 онд үйлдвэрлэгдсэн УАЗ-3962 маркийн автомашиныг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 108 дугаар хуралдааны тогтоолоор акталж, дуудлага худалдаагаар худалдах зөвшөөрөл олгосны дагуу данс бүртгэлээс хассан.

Оны эхэнд 19.2 сая төгрөгийн эмийн, 2.4 сая төгрөгийн шатахууны өглөгтэй байсныг бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 507.8 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 42.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүждэг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 695.0 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 666.9 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 28.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 549.7 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 28.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 578.5 сая төгрөг буюу 83.2 хувьтай байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр 97.5 сая төгрөгийн санхүүжилтийг сангаас дутуу авсантай холбоотой. Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжилтээ дутуу авсан ч жилийн эцэст өргүй гарсан байна.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80302-Нэг иргэнд ногдох нормативаар	315,303.9	283,964.9	31,339.0	90.1
2	81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	303,651.7	217,793.6	85,858.1	71.7
3	83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	47,977.5	47,977.5	-	100.0
4	80112-Нийтлэг үйлчилгээ	28,799.0	28,799.0	-	100.0
	Дүн	695,732.1	578,535.0	117,197.1	83.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар санхүүжилт аваагүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Буянт сумын Эрүүл мэндийн төв нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 505.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 594.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Тус 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 90.6 сая төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад эрхлэгчид ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлсэн шийдвэргүйгээр 1.1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал, зарим албан хаагч нарт 0.6 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад хуулийн дагуу мэдээллээ хугацаанд нь бүрэн оруулсан байна. Мэдээлсэн байдлын хэрэгжилтийн 100 хувь байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 11.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 9.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр дараах зөрчлүүдэд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн төвийн эмийн сангаас хугацаа дууссан 65 нэр төрлийн 1.3 сая төгрөгийн эмийг акталж данс бүртгэлээс хассан боловч тухайн эмүүдийн хугацаа дууссан, хэрэглэх боломжгүй болсон талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулаагүй, устгалт хийсэн тэмдэглэл байхгүй, устгал хийснийг зурагжуулж баримтжуулаагүй.

2. Тайлант оны 6, 9, 12 дугаар сарууд нэр бүхий ажилчдад 0.6 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг хууль, журам зөрчиж олгосон.

5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Тайлант онд нормын хувцасны зардлын батлагдсан төсвөөс 0.8 сая төгрөгийг, урсгал засварын батлагдсан төсвөөс 0.4 сая төгрөгийг, багаж, техник хэрэгслийн зардлын батлагдсан төсвөөс 0.3 сая төгрөгийг, нийт 1.6 сая төгрөгийг Төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн Төрийн сангийн зохих зөвшөөрөлгүйгээр аж ахуйн материалын зардалд зориулалт бусаар шилжүүлэн зарцуулсан.

2.Тээврийн хэрэгсэлд хийлгэсэн 0.8 сая төгрөгийн доторлогооны нотлох баримтуудыг дутуу бүрдүүлсэн, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй.

3.Төсвийн хөрөнгөөр шинээр худалдаж авсан цаашид хэрэглэгдэх 5.5 сая төгрөгийн гал тогооны төхөөрөмж, ажилчдын нормын хувцсыг шууд зарлагдаж данс бүртгэлээс хассан

4.Эрүүл мэндийн төвийн эрхлэгчид томилсон эрх бүхий албан тушаалтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлсэн шийдвэргүйгээр 1.1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал, мөн 0.2 сая төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг хууль, журам зөрчиж олгосон.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулаг үй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүйгээр эм акталж, данс бүртгэлээс хассан	1	1304.9	1	1304.9								
Гүйлгэн зарцуулах зөвшөөрөлгүй зардал хооронд	1	1585.0			1	1585.0						

Буянт сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

гүйлгэн зарцуулалт хийсэн												
Дүн	3	9194.9	1	1304.9	1	7890.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлттэй холбоотой зөрчил								
Журам зөрчиж урамшуулал, илүү цагийн хөлс олгосон	2	2002.1	1	614.1	1	1388.0		
Төсвийн хөрөнгөөр шинээр худалдаж авсан хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан, дутуу материалаар хөрөнгө зарцуулсан	1	6305.0			1	6305.0		
Дүн	3	8307.1	1	614.1	1	7693.0		
Нийт дүн	3	8307.1	1	614.1	1	7693.0		